



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн өргөн
чөлөө 3, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101 Утас: (976) 70442273
Цахим шуудан: info@bayanhongor.gov.mn
Цахим хаяг: www.bayanhongor.gov.mn

2025.04.10 № 2/475
танай _____ -ны № _____ -т

Г ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН Г
БАЙГУУЛЛАГУУДЫН ДАРГА,
ЭРХЛЭГЧ НАРТ

Төрийн болон Орон нутгийн өмчийн
байгууллагуудын 2024 оны жилийн үйл
ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн
нэгдсэн тайлан, зөвлөмжийг хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт хуудастай

ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ЗӨВЛӨМЖ

2024 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 11

Номгон

Төрийн болон Орон нутгийн өмчийн
байгууллагуудын 2024 оны жилийн үйл
ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ
хийсэн тухай

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт, бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт, зөвлөмж өгөх, бодлого, үйл ажиллагааны үр нөлөө, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн 11 байгууллагын 2024 оны жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн арга хэмжээнүүдийн үр дүнг нэмэгдүүлэх арга хэмжээг авах;

2.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол шийдвэр, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй, хугацаа болоогүй заалт тус бүрийг хяналтад авч, нэмэлт төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг бүрэн хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн дагуу төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, сахилга хариуцлагыг дээшлүүлэх;

3.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээг үр дүнд чиглүүлж, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинг тодорхой, оновчтой, үр дүнг илэрхийлэхүйц, хэмжих боломжтой байдлаар салбарын албан ёсны статистик үзүүлэлтэд суурилж, салбарын бодлоготой уялдуулан тодорхойлох, хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, хэрэгжилт удаашралтай, хангалтгүй арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч, тухайн жилийн хэрэгжилтийг шаардагдах санхүүжилт, бодит үр дүнд тулгуурлан тайлагнах;

642535023

4.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг тус тус баримтлан ажиллаж байгууллагын албан ёсны цахим хуудас, ил тод байдлын самбар, бусад сувгуудаар хэрхэн ил тод мэдээлж, хэдэн хүнд хүргэсэн, мэдээллийг ямар давтамжтай сольсон, ямар эх сурвалжаас тухайн мэдээллийг дэлгэрэнгүй бүрэн авах боломжтой зэрэг үр дүнг тайланд тавих шаардлагад нийцүүлэн тайлагнах, албан ёсны цахим хаягийг тайланд дурдах;

5.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх, төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг цахим тайланд файлаар хавсарган ирүүлэх;

6.Жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээгээр хангалтгүй үнэлгээ авсан Автотээврийн төв, Сум дундын ойн анги ОНӨААТҮГ, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс зэрэг байгууллагууд үйл ажиллагаагаа сайжруулах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг эрчимжүүлэн үйл ажиллагааны үр дүн, чанарыг нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

7.Зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 25, 2025 оны 12 дугаар сарын 25-ны дотор аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тайлагнахыг зөвлөж байна.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2025 оны 03 дугаар сарын 20

Номгон

Нэг.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, аргачлал, хамрах хүрээ:

Төрийн болон Орон нутгийн өмчийн 11 байгууллагын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт, бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт, зөвлөмж өгөх, бодлого, үйл ажиллагааны үр нөлөө, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх, зорилгоор 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг үнэлэхдээ Аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгов.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээнд:

- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;
- Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлт;
- Дэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээнд:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт;
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэр;
- Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт;
- Зөвлөмжийн хэрэгжилт;

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн хэрэгжилтийн үнэлгээнд:

- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан;
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлт;
- Байгууллагын ил тод байдлын үнэлгээ;
- Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн үнэлгээ;
- Шилэн данс;
- Байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой шалгуур үзүүлэлт

Засгийн газрын тэргүүлэх чиглэлийн үнэлгээнд:

- Ногоон байгууламж (Мод тарих)
- Цахим шилжилт зэрэг 17 тайланг хянаж, үнэлгээг тооцсон.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тус байгууллагаас цаасан болон цахим хэлбэрээр ирүүлсэн тайлан, байгууллагын цахим хуудас зэрэгтэй харьцуулалт хийж үнэлсэн болно.

Тайлангуудаас Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Дэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэр, Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлт, Байгууллагын ил тод байдлын үнэлгээ, Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт, Зөвлөмжийн хэрэгжилт, Байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой шалгуур үзүүлэлт зэрэг 11 тайланг Баянхонгор аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангаар хүлээн авч үнэлсэн.

Дээрх цахим тайлангуудын хэрэгжилтийн дэлгэрэнгүй үнэлгээг <http://bayankhongor.igovernment.mn> цахим хуудаснаас үзэх боломжтой.

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх чиглэл Ногоон байгууламж (Мод тарих), Цахим шилжилт төсөл хөтөлбөр, Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээг тухайн байгууллагаас цаасаар ирүүлсэн тайланд үндэслэн дүгнэв.

Архив, албан хэрэг хөтлөлтийн үнэлгээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн архивын тасгийн үнэлгээгээр, Шилэн дансны үнэлгээг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үнэлгээгээр дүгнэлээ.

Хоёр.Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагуудын 2024 онд хяналтад авч хэрэгжүүлэн тайлагнасан арга хэмжээ, үнэлгээг тайлан тус бүрээр танилцуулъя.

2.1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 50 арга хэмжээг Төрийн болон Орон нутгийн өмчийн 10 байгууллага хэрэгжүүлснээс Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Баянхонгор Эрчим хүч цахилгаан түгээх ХХК, “Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах

эмчилгээний төв, Цэвэр хот ОНӨААТҮГазар, Баянхонгор тохижилт ОНӨТБ, Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци “Үр дүнтэй”, Автотээврийн төв, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа, Сум дундын ойн анги ОНӨААТҮГ, Чандмань Баянхонгор ХК “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдэн, байгууллагуудын дундаж үнэлгээ 94.87 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үзүүлэлттэй байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 86.7 хувиас 94.87 хувь болж 8.17 хувиар ахисан байна.

Хүснэгт 1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Д/д	Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Арга хэмжээний тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)				Тайлагнаагүй	Үнэлгээ
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй		
1	2	3	4	5	6	7	8	9
1	Автотээврийн төв	6	5	-	-	1	-	83,33%
2	Баянхонгор тохижилт ОНӨТБ	4	4	-	-	-	-	100%
3	Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	9	9	-	-	-	-	100%
4	Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	8	7	1	-	-	-	98,75%
5	“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	5	5	-	-	-	-	100%
6	Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	3	3	-	-	-	-	100%
7	Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	6	4	1	1	-	-	87,5%
8	Цэвэр хот ОНӨААТҮГ	3	3	-	-	-	-	100%
9	Чандмань Баянхонгор ХК	5		4	-	1	-	79,20%
10	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	1	1	-	-	-	-	100%
Нийт дүн		50	41	6	1	2	-	94.87%
Үнэлгээнд эзлэх хувь		100	82%	12%	2%	4%	-	-

2.2. Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ:

Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг Төрийн болон Орон нутгийн өмчийн 10 байгууллага хэрэгжүүлж, байгууллагуудын дундаж үнэлгээ 92,48 хувьтай үнэлэгдснээс Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Сум дундын ойн анги ОНӨААТҮГ, “Цэвэр хот” ОНӨААТҮГ, Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци “Үр дүнтэй”, бусад байгууллагууд “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдлээ. Өнгөрсөн онд 71.1 хувьтай үнэлэгдсэн ба энэ онд 21.38 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2. Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Тайлагнаагүй	Дундаж үнэлгээ (%)
1	2	3
Автотээврийн төв	-	82,5%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	-	97
Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	-	74,7%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	-	92,1%
“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	-	96%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	-	100%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	-	100%
Цэвэр хот ОНӨААТҮГ	-	100%
Чандмань Баянхонгор ХК	-	82,5%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	-	100%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	-	-
Нийт дүн	-	92,48%

2.3. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Аймгийн дэд хөтөлбөрүүдээс давхардсан тоогоор 9 дэд хөтөлбөрийн 56 арга хэмжээг Төрийн болон Орон нутгийн өмчийн 11 байгууллага дунджаар 83,46 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Чандмань Баянхонгор ХК “Үр дүнтэй”, Баянхонгор тохижилт ОНӨТБ, Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа, “Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв, Сум дундын ойн анги ОНӨААТҮГ, Цэвэр хот ОНӨААТҮГ, Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци “Тодорхой үр дүнд хүрсэн”, Автотээврийн төв, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн. Өнгөрсөн оны мөн үеэс (73.3 хувь) 10.16 хувиар ахисан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Хөтөлбөрийн тоо	Арга хэмжээний тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)				Тайлагнаагүй	Дундаж үнэлгээ (%)
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй		
1	2	3	4	5	6	7	8	9
Автотээврийн төв	2	2	-	1	1	-	-	60%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	2	3	2	1	-	-	-	97,5%

1	2	3	4	5	6	7	8	9
Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	1	2	-	2	-	-	-	80%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	2	3	1	2	-	-	-	92,5%
"Жаргалтай амьдрал" сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	2	3	2	1	-	-	-	97,5%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	1	1	1	-	-	-	-	100%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	1	1	-	1	-	-	-	70%
Цэвэр хот ОНӨААТҮГ	2	3	1	1	1	-	-	72,5%
Чандмань Баянхонгор ХК	1	1	1	-	-	-	-	100%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	1	2	-	2	-	-	-	80%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	1	38	18	8	5	7	-	68,16%
Нийт дүн	16	59	26	19	7	7	-	83,46%
Үнэлгээнд эзлэх хувь		100	44.06%	32.20%	11.87%	11.87%	-	-

2.4.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Монгол Улсын хууль, Улсын Их хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар үүрэгжүүлэн өгсөн нийт 66 заалтын хэрэгжилтийг хянан үзэхэд дунджаар 78.09 хувиар үнэлэгдэв. Өнгөрсөн оны мөн үеэс (75.1 хувь) 2.99 хувиар өссөн байна.

Хүснэгт 4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)					Тайлагнаагүй	Дундаж үнэлгээ (%)
			Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй		
1	2	3	4	5	6	7	8	9	10
Автотээврийн төв	5	5	2	-	-	1	2	-	66.67%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	4	4	1	1	1	-	1	-	66.67%
Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	6	6	4	1	-	1	-	-	78.33%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	7	8	4	3	-	-	1	-	87.14%
"Жаргалтай амьдрал" сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	5	5	3	1	-	1	-	-	74%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	7	7	5	-	-	-	2	-	100%

1	2	3	4	5	6	7	8	9	10
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	7	7	5	1	-	-	1	-	95%
Цэвэр хот ОНӨААТҮГ	6	6	5	1	-	-	-	-	95%
Чандмань Баянхонгор ХК	6	6	1	2	-	2	1	-	48%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	13	13	6	2	-	1	4	-	82.22%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	6	6	3	-	1	1	1	-	66%
Нийт дүн	72	73	39	12	2	7	13	-	78.09%
Үнэлгээнд эзлэх хувь		100	53.4%	16.4%	2.7%	9.6%	17.9%	-	

2.5.Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2-3 тогтоол, шийдвэрийн 23 заалтыг Төрийн болон Орон нутгийн өмчийн 11 байгууллага дунджаар 83.18 хувьтай хэрэгжүүлсэн. Өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлттэй харьцуулахад -2.37 хувиар буурсан байна.

Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК, Цэвэр хот ОНӨААТҮГ, Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци зэрэг байгууллагууд “Үр дүнтэй”, Автотээврийн төв, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа, “Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв, Сум дундын ойн анги ОНӨААТҮГ, Чандмань Баянхонгор ХК “Тодорхой үр дүнд хүрсэн”, Баянхонгор тохижилт ОНӨТБ, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн.

Хүснэгт 5. Аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)				Хугацаа болоогүй	Дундаж үнэлгээ (%)
			Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй		
1	2	3	4	5	6	7	8	9
Автотээврийн төв	2	2	1	1	-	-	-	85%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	2	2	1	-	1	-	-	65%
Баянхонгор Эрчим хүч, ЦТ ХХК	2	2	2	-	-	-	-	100%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	3	3	2	1	-	-	-	90%
“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	2	2	-	1	-	-	1	70%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	2	2	2	-	-	-	-	100%

1	2	3	4	5	6	7	8	9
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	2	2	1	1	-	-	-	85%
Цэвэр хот ОНӨААТҮГ	2	2	2	-	-	-	-	100%
Чандмань Баянхонгор ХК	2	2	-	-	-	-	-	70%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	2	2	1	-	-	1	-	50%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	2	2	2	-	-	-	-	100%
Нийт дүн	2-3	23	14	6	1	1	1	83.18%
Үнэлгээнд эзлэх хувь		100	60.87%	26.08%	4.35%	4.35%	4.35%	

2.6. Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаарын хэрэгжилтийн үнэлгээ:

Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилтийн тайлант 2024 онд улирал тутамд үнэлгээг хийсэн. Тайлант 2024 оны байдлаар 124 захирамж, албан даалгаврын 396 заалтыг Төрийн болон Орон нутгийн өмчийн 11 байгууллага “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу дундаж хэрэгжилт 86.48 хувьтай хэрэгжүүлсэн байна. Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа “Үр дүнтэй”, Автотээврийн төв, Баянхонгор аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтэс “Эрчимжүүлэх шаардлагатай” бусад байгууллагууд “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.68 хувиар өссөн байна.

Хүснэгт 6. Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаарын хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)					Тайлагнаагүй	Дундаж үнэлгээ (%)
			Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй		
1	2	3	4	5	6	7	8	9	10
Автотээврийн төв	12	37	18	7	6	6	-	-	66.76%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	10	35	27	6	1	-	1	-	92.65%
Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	11	35	33	1	1	-	-	-	97.14%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	12	36	36	-	-	-	-	-	100%
“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	11	36	32	2	-	-	2	-	98.24%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	10	35	30	5	-	-	-	-	95.71%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	13	39	27	6	6	-	-	-	84.62%
Цэвэр хот ОНӨААТҮГ	10	35	33	1	1	-	-	-	97.14%

1	2	3	4	5	6	7	8	9	10
Чандмань Баянхонгор ХК	12	36	24	9	3	-	-	-	86.67%
Баянхонгор аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	11	34	10	3	5	16	-	-	40%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	12	38	29	7	1	-	1	-	92.43%
Нийт дүн	124	396	299	47	24	22	4	-	86.48%
Үнэлгээнд эзлэх хувь		100	75.5%	11.9%	6.1%	5.5%	1%		

2.7.Зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ:

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд 2023 оны жилийн эцэс, 2024 оны хагас жилээр хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дагуу өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг цахим системээр үнэлсэн бөгөөд 11 байгууллагаас Сум дундын ойн анги ОНӨААТҮГ тайлагнаагүй.

Зөвлөмжийн хэрэгжилт 77.92% болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 49.63 хувиар өссөн, цагалбарын дагуу тайлагнасан ахиц гарсан.

Хүснэгт 7. Зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)				Тайлагнаагүй	Дундаж үнэлгээ (%)
			Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй		
1	2	3	4	5	6	7	8	9
Автотээврийн төв	2	13	2	3	4	4	-	40.77%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	2	11	11	-	-	-	-	100%
Баянхонгор Эрчим хүч, ЦТ ХХК	2	11	11	-	-	-	-	100%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	2	11	10	-	-	1	-	90.91%
"Жаргалтай амьдрал" сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	2	12	12	-	-	-	-	100%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	2	11	11	-	-	-	-	100%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	2	11-	-	-	-	-	11	0%
Цэвэр хот ОНӨААТҮГ	2	12	12	-	-	-	-	100%
Чандмань Баянхонгор ХК	2	12	7	4	1	-	-	84.17%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	2	13	2	4	3	4	1	43.85%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	2	12	11	1	-	-	-	97.50%
Нийт дүн	22	129	89	12	8	9	11	77.92%
Үнэлгээнд эзлэх хувь		100	69%	9.3%	6.2%	7%	8.5%	

2.8. Байгууллагын гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээ:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагуудын 80 хувь нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг цахим системээр тайлагнасан. Авто тээврийн төв төлөвлөгөө, тайланг хугацаа хоцроон тайлагнаснаас үнэлгээ хийгдээгүй, харин Төрийн цахим үйлчилгээний хэлтэс тайлагнаагүй байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө нь тухайн байгууллагын үйл ажиллагааны үндсэн баримт бичиг бөгөөд тайланг хянан үзэхэд тайлагнасан 8 байгууллага “Тодорхой үр дүнд хүрсэн”, 1 байгууллага буюу Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдлээ.

Хэрэгжилтийн дундаж үнэлгээ 74.8 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад -1.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 8. Байгууллагуудын гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Арга хэмжээ	Үнэлгээ					Дундаж хувь
		Үүний дотор /Арга хэмжээний тоо/					
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Хугацаа болоогүй	
1	3	4	5	6	7	8	9
Автотээврийн төв	53	-	-	-	-	53	0%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	33	27	4	2	-	-	93.33%
Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	21	11	7	3	-	-	81.9%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	45	33	8	3	1	-	88.22%
“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	26	17	6	3	-	-	88.08%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	22	16	5	1	-	-	90.91%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	27	13	8	6	-	-	80%
Цэвэр хот ОНӨААТҮГ	36	30	2	3	1	-	90.28%
Чандмань Баянхонгор ХК	44	26	9	9	-	-	82.27%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	31	-	-	-	-	31	0%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	33	11	7	4	11	-	53.03%
Нийт дүн	371	184	56	34	13	84	74.8%
Үнэлгээнд эзлэх хувь	100	49.6%	15.1%	9.2%	3.5%	22.6%	

2.9. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг дунджаар 82.46 хувьтай дүгнүүлсэн.

Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7.46 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт байгууллагуудын 27.2 хувь нь “Үр дүнтэй, 66.6 хувь нь “Тодорхой үр дүнд” хүрсэн гэж үнэлэгдсэн бол Төрийн цахим үйлчилгээний хэлтэс тайлангийн хэрэгжилтийг ирүүлээгүй байна.

Хүснэгт 9. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Байгууллагын нэр	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)					Дундаж үнэлгээ (%)
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Тайлагнаагүй	
1	2	3	4	5	6	7	8
Автотээврийн төв	7	6	-	-	1	-	85.71%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	7	7	-	-	-	-	100%
Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	7	6	-	-	1	-	85.71%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	7	5	1	-	1	-	84.29%
“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	7	6	-	-	1	-	85.71%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	7	6	-	-	1	-	85.71%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	7	7	-	-	-	-	100%
Цэвэр хот ОНӨААТҮГ	7	5	1	-	1	-	84.29%
Чандмань Баянхонгор ХК	7	7	-	-	-	-	100%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	7	4	3	-	-	-	95.71%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	7	-	-	-	-	7	0%
Нийт дүн	77	59	5	-	6	7	82.46%
Үнэлгээнд эзлэх хувь	100%	76.6%	6.5%	-	7.8%	9.1%	

2.10. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээ:

Байгууллагын ил тод байдлыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн 5 төрлийн 46 мэдээлэл тус бүрээр 10 байгууллага

тайлагнасныг хянан үзэхэд байгууллагуудын дундаж үнэлгээ 53.56 хувьтай байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 28.96 хувиар өссөн хэдий ч хангалтгүй үзүүлэлт юм.

Цэвэр хот ОНӨААТҮГ, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа “Үр дүнгүй”, Автотээврийн төв, “Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв, Сум дундын ойн анги ОНӨААТҮГ “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж дүгнэгдсэн бол бусад байгууллагууд 70.74-93.33 хувиар “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдсэн.

Шалгуур үзүүлэлтийг байгууллагын албан ёсны цахим хуудас, ил тод байдлын самбар, бусад сувгуудаар хэрхэн ил тод мэдээлж, хэдэн хүнд хүргэсэн, мэдээллийг ямар давтамжтай сольсон, ямар эх сурвалжаас тухайн мэдээллийг дэлгэрэнгүй бүрэн авах боломжтой талаар тайлагнах ёстой байтал тухайн заалтын хүрээнд зохион байгуулсан ажлыг тайлагнах, өөрсдийн хийсэн ажлыг бүрэн тайлгнаж чадахгүй орхигдуулах дутагдал давтагдсаар байна.

Хүснэгт 10. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Шийдвэрийн тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)					Тайлагнаагүй	Дундаж үнэлгээ (%)
		Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй /үнэлэгдээгүй		
1	2	3	4	5	6	7	8	9
Автотээврийн төв	46	12	1	1	13	19	-	48.15%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	46	13	12	2	3	16	-	73.33%
Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	46	19	14	-	5	8	-	75.79%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	46	2	5	2	15	22	-	25.42%
“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	46	4	11	3	5	23	-	54.78%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	46	21	6	-	-	19	-	93.33%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	46	8	9	-	6	23	-	62.17%
Цэвэр хот ОНӨААТҮГ	46	-	4	1	25	16	-	10.33%
Чандмань Баянхонгор ХК	46	12	8	5	2	19	-	70.74%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	46	14	6	2	3	21	-	75.20%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	-	-	-	-	-	-	-	-
Нийт	460	105	76	16	77	186	-	53.56%
Үнэлгээнд эзлэх хувь	100	22.8%	16.5%	3.5%	16.8%	40.4%	-	

2.11. Архив, албан хэрэг хөтлөлтийн үнэлгээ:

Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны үнэлгээ өнгөрсөн оны мөн үед дунджаар 46 хувьтай үнэлэгдсэн бол тайлант хугацаанд 69 хувьтай үнэлэгдэж, 23% -иар өссөн байна.

Төрийн цахим үйлчилгээний хэлтэс үнэлэх боломжгүй гэж дүгнэгдсэн байна.

Хүснэгт 11. Байгууллагын архивын үнэлгээ:

Д/д	Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Архив, албан хэрэг хөтлөлтийн үнэлгээ
1	2	3
1	Автотээврийн төв	30
2	Баянхонгор тохижилт ОНӨТБ	90
3	Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	70
4	Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	100
5	"Жаргалтай амьдрал" сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	20
6	Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	80
7	Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	100
8	Цэвэр хот ОНӨААТҮГ	80
9	Чандмань Баянхонгор ХК	80
10	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	40
11	Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	-
Дундаж үнэлгээ		69%

2.12. Засгийн газрын болон байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ:

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, Хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын үнэлгээг байгууллагуудын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст ирүүлсэн цаасан тайланд үндэслэн дүн шинжилгээ хийж үнэлж дүгнэлээ.

Ногоон байгууламжийн үнэлгээг "Тарьсан модны тоо", "Ургалтын хувь", "Байгууллагын эзэмшил газрын ногоон байгууламжийн хувь" зэрэг шалгуур үзүүлэлтээр үнэлсэн бөгөөд байгууллагуудын 90% тайланг ирүүлэн, дунджаар 81.81%-тай үнэлэгдлээ. Автотээврийн төв, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс тайланг ирүүлээгүй байна.

Бусад байгууллагууд 100 хувь буюу "Үр дүнтэй" гэж үнэлэгдсэн.

Цахим шилжилт арга хэмжээний тайланг Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс Цахим үйлчилгээ, Цахим хуудас ашиглалт, ERP систем, албан бичиг программ DOCX системд холбогдсон эсэх үзүүлэлтээр дүгнэж ирүүлснийг үнэлгээнд оруулсан болно.

Үнэлгээгээр Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК, Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Сум дундын ойн анги ОНӨААТҮГ, Цэвэр хот ОНӨААТҮГ, Чандмань Баянхонгор ХК, Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн бол Автотээврийн төв, Баянхонгор тохижилт ОНӨТБ, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа, “Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв 62.06-66.42 хувь буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдэн, дундаж үнэлгээ 70.94% -тай үнэлэгдсэн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Ногоон байгууламжийн үнэлгээ 3.51 хувиар өсч, харин Цахим шилжилтийн үнэлгээ -6.56 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 12. Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн үнэлгээ:

Д/д	Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Үнэлгээ	
		Ногоон байгууламж нэмэгдүүлэх	Цахим шилжилт
1	2	3	4
1	Автотээврийн төв	0%	62.43%
2	Баянхонгор тохижилт ОНӨТБ	100%	66.42%
3	Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	100%	74.45%
4	Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	100%	65.08%
5	“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	100%	62.06%
6	Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	100%	81.2%
7	Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	100%	70.97%
8	Цэвэр хот ОНӨААТҮГ	100%	74.96%
9	Чандмань Баянхонгор ХК	100%	80.12%
10	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	100%	72%
11	Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	0%	-
	Дундаж үнэлгээ	81.81%	70.94%

2.13. Байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээ:

Байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт тайланд онд цахим санд байршсан. Төрийн болон Орон нутгийн өмчит байгууллагуудын тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн тайлангийн дундаж үнэлгээ 88.77% хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдсэн байна.

Үнэлгээгээр 11 байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой 39 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд гүйцэтгэлийн хувь 2023 онд 85.4% байсан бол 2024 онд 88.77% болж 3.37%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Хэрэгжилтийг Төрийн цахим үйлчилгээний хэлтэс ирүүлээгүй байна.

Байгууллагуудын тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр:

“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төвөөр 586 иргэнийг хүлээн авч сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлсэн ба архинд донтох эмгэгтэй 2500 иргэнээс зорилтот бүлгийн 23,4%-д буюу 94 иргэнийг үндсэн болон сэргээх хөтөлбөрт хамруулсан;

Өнгөрсөн 2020-2024 онд үйлчлүүлсэн иргэдээс түүврээр 130 хүнд хяналт хийхэд үр дүн гарсан 16%, архи хэрэглэх зай холдсон 45%, дахилт өгсөн 34% дүн гарсан;

Сэтгэл зүй нийгэм, хууль эрх зүйн үйлчилгээний мэдээллээр хангах сургалтуудыг зохион байгуулж 69 байгууллагын 1832 ажилтан, албан хаагчдыг хамруулсан;

“Донтолтын шинж тэмдгүүд түүнээс урьдчилан сэргийлэх” талаарх сургалтыг нийт насанд хүрсэн 236 иргэнд хүргэсэн;

Байгууллагад суурилсан нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх дэмжих бүлгийг эхлүүлж, 51 иргэн хамруулсан;

"Салбар дундын хамтын ажиллагаа-Нийгмийн ажил үйлчилгээний зураглал" боловсруулж, оролцогч талуудын үүргийг тодорхой болгосон ба аймгийн төв болон сумдаас хүлээн авах үйлчлүүлэгчийн тоо, хуваарийг батлуулсан;

Түйн гол дагуу татам тариалалтад 3,000 ширхэг цагаан бургас, 13 нэр төрлийн 800 ширхэг модыг Арван мянгатын ойн зурваст болон аж ахуй нэгж айл өрхүүдэд худалдан борлуулснаар 3,800 ширхэг модыг тариалж ногоон байгууламжыг нэмэгдүүлсэн;

Хуванцар 7,2 тн, ажилласан тос масло 2860 литр, аккумулятор 11 ширхэг, агаар шүүгч 8 ширхэгийг ангилах цэгт хүлээн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хуванцар ангилалт 50 %-иар буурч, эсрэгээрээ тос маслын ангилалт 53,3 %-иар өссөн;

Гэр хорооллын 9283 өрх, орон сууцны 2290 өрх, төрийн 54 байгууллага, хувийн хэвшлийн аж ахуй нэгж 153, хүнсний дэлгүүр 148, нийт 350 гаруй иргэн аж

ахуй нэгжийн эздүүдтэй хог хаягдал тээвэрлэх гэрээг 100%-тай байгуулан төвлөрсөн хогийн цэгт хог тээврийн 14 авто машинаар 4888 удаагийн рейсээр 39096 тн хог хаягдал тээвэрлэсэн;

Ус хангамжийн төв шугамын хуваарилах худагт Ф250мм-ийн хаалт-2ш, Ф219мм-ийн 2ш хаалтыг 14,0 сая төгрөгийн санхүүжилтээр бүрэн шинэчлэсэн нь төв шугамын хаалтыг хуваарилан хаах боломжтой болж, хоногт 15м³ орчим усны алдагдлыг засварлаж, усны алдагдлыг 0,5 хувиар бууруулсан;

Нийт 24 иргэн, аж ахуй нэгжид зээл олгож 94 ажлын байр шинээр бий болсон ба 405,445,432 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг төвлөрүүлсэн;

Нийт 8 аж ахуй нэгж 1,186,422м³ саарал усыг эргүүлэн ашигласан зэрэг үр дүн гарсан байна.

Хүснэгт 13. Байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой шалгуур үзүүлэлтийн үнэлгээний дүн:

Д/д	Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн үнэлгээ
1	2	3
1	Автотээврийн төв	100%
2	Баянхонгор тохижилт ОНӨТБ	99.50%
3	Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	100%
4	Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	100%
5	“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	100%
6	Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	100%
7	Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	91.67%
8	Цэвэр хот ОНӨААТҮГ	93%
9	Чандмань Баянхонгор ХК	100%
10	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	92.33%
11	Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	0%
Дундаж үнэлгээ		88.77%

Сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилт

Засгийн газрын гишүүн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг Төрийн болон Орон нутгийн өмчийн 10 байгууллага дунджаар 92.78 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 14. Сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийн дүн:

Д/д	Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийн үнэлгээ
1	2	3
1	Автотээврийн төв	100%
2	Баянхонгор тохижилт ОНӨТБ	-
3	Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	100%
4	Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	70%
5	"Жаргалтай амьдрал" сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	100%
6	Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	100%
7	Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	100%
8	Цэвэр хот ОНӨААТҮГ	100%
9	Чандмань Баянхонгор ХК	62.67%
10	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	100%
11	Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	95.14%
Дундаж үнэлгээ		92.78%

Гурав. Дүгнэлт:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд нь 2024 онд давхардсан тоогоор 177 хэрэгжилтийн тайлан ирүүлэхээс 14 тайлан буюу 7.9 хувийг хугацаа хоцроосон, 6 тайлан буюу 3.38 хувийг тайлагнаагүй нь өмнөх оны мөн үеэс буурч тайлангийн ирц харьцангуй сайжирсан. Дурдвал: Хугацаа хоцроосон 3 тайлангаар буюу 2.59 хувиар, тайлагнаагүй 4 тайлангаар буюу 2.72 хувиар буурсан. Гэвч тайлан хоцроох, тайлагнаагүй байх зөрчил бүрэн арилаагүй байна.

"Жаргалтай амьдрал" сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв 64.54 хувь, Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК 56.73 хувиар үнэлгээгээ ахиулж, тайлангийн таслалдалгүй ажлаа сайжруулж ажилласан нь сайшаалтай байна.

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагуудын 2024 оны Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр 9 байгууллага буюу 81.8% хувь нь "Тодорхой үр дүнд хүрсэн", 2 байгууллага буюу 18.2 хувь нь "Эрчимжүүлэх шаардлагатай", 1 байгууллага "Үр дүнгүй" гэж үнэлэгдсэн.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагуудын дундаж үнэлгээ 56.01 хувиас 72.51 хувь болж өссөн ахиц гарсан байна.

Хүснэгт 14.Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагуудын 2024 оны жилийн үйл ажиллагааны үнэлгээний дүн:

Байгууллагын нэр	Тайлагнавал зохих тайлангийн тоо	Дундаж үнэлгээ	Хоцроосон тайлангийн тоо	Тасалсан тайлангийн тоо	Ерөнхий үнэлгээ
1	2	3	4	5	6
Автотээврийн төв	16	57.42%	2	1	48.42%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	16	88.15%	-	-	88.15%
Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	17	83.48%	-	-	83.48%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	16	84.74%	2	-	80.74%
“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	17	81.04%	1	-	79.04%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	16	94.76%	1	-	92.76%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	17	79.24%	5	1	64.24%
Цэвэр хот ОНӨААТҮГ	17	86.64%	1	-	84.64%
Чандмань Баянхонгор ХК	17	81.08%	-	-	81.08%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	17	82.73%	-	-	82.73%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	11	36.42%	2	4	12.42%
Нийт дүн	177	77.8%	14	6	72.51%

*Цахим мэдээллийн сангийн бүртгэлээр хоцроосон, тайлагнаагүй тайланг үнэлгээнд тооцсон болно.

Тайлант 2024 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг 2023 оны мөн үетэй харьцуулан үзэхэд Баянхонгор тохижилт ОНӨТБ 14.55 хувь, Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК 4.69 хувь, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа 3.64 хувь, Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа 26.56 хувь, Цэвэр хот ОНӨААТҮГ 21.84 хувь, Чандмань Баянхонгор ХК 4.03 хувиар тус тус үнэлгээгээ ахиулж “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн байна.

Автотээврийн төв 14.92 хувиар, Сум дундын ойн анги ОНӨААТҮГ 13.64 хувиар тус тус ахисан хэдий ч шаардлагатай хэмжээнд хүрээгүй “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн.

Харин Төрийн цахим үйлчилгээний хэлтэс 2024 оны хагас жилд 21.2 хувьтай тайлагнаж байсан бол жилийн эцэст 12.42 хувиар үнэлэгдэн -8.78 хувиар бууруулж “Үр дүнгүй” гэж үнэлэгдсэн байна. Түүнчлэн Засгийн газрын тэргүүлэх ач

холбогдолтой Цахим шилжилт арга хэмжээний тайланг хангалтгүй тайлагнасан, албан ёсоор баталгаажуулж ирүүлээгүй зэрэг алдаа дутагдлыг гаргаж хариуцлагагүй ажилласан байна.

Тайлангийн чанарт ахиц гарахгүй байгаа шалтгаан нь;

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн зөвлөмжийн ирц сайжирсан ч, төлөвлөгөөг нарийвчлан боловсруулан хэрэгжүүлж ажиллаагүй, гүйцэтгэл хангалтгүй үйл ажиллагааг төлөвлөхдөө зохих албан тушаалтанд хариуцуулан хэрэгжилтийг тооцоогүй, хэрэгжилтийн чанарт анхаараагүй.

2.Аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу ирүүлээгүй тайлан тус бүрийг 5 оноогоор, хугацаа хоцроосон тайлан тус бүрийг 2 оноогоор тооцон тухайн байгууллагын ерөнхий дундаж онооноос хасаж тооцох зохицуулалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.

3.Тайлангийн ирц ахисан хэдий ч тайлангийн чанарт анхаарахгүй үр дүнг тайлагнахгүй, болсон үйл явдлыг тоочиж хүүрнэсэн, төрийн албан хаагчдын ажилдаа хандах хандлага, сахилга, хариуцлага суларсан, төлөвлөсөн арга хэмжээний хүрээнд тодорхой ажил зохион байгуулдаггүй, удирдлага зохион байгуулалт, удирдлагын хяналт муу байгаатай холбоотой үзэж байна.

Хүснэгт 17. Байгууллагуудын 2024 оны жилийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Байгууллагын нэр	2023 оны хагас жилийн үнэлгээ	2024 оны хагас жилийн үнэлгээ	Өөрчлөлт	2023 оны жилийн үнэлгээ	2024 оны жилийн үнэлгээ	Өөрчлөлт
1	2	3	4	5	6	7
Автотээврийн төв	29.93%	7.3%	37.23	33.5%	48.42%	14.92%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	52.6%	69.5%	16.9	73.6%	88.15%	14.55%
Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	6.71%	77.1%	70.39	78.79%	83.48%	4.69%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	19.7%	71.5%	51.8	77.10%	80.74%	3.64%
“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	26.5%	57.6%	31.1	14.5%	79.04%	64.54%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	46.51%	89.3%	42.79	66.20%	92.76%	26.56%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	14%	30.1%	16.1	50.6%	64.24%	13.64%
Цэвэр хот ОНӨААТҮГ	25.5%	75.7%	50.2	62.80%	84.64%	21.84%

1	2	3	4	5	6	7
Чандмань Баянхонгор ХК	73.6%	70%	-3.6	77.05%	81.08%	4.03%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	-47.3%	51.5%	98.8	26%	82.73%	56.73%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	-	21.2%	21.2	-	12.42%	12.42%
Нийт дүн	18.8%	56.43%	37.6	56.01%	72.51%	16.5%

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэр, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй, хугацаа болоогүй заалт тус бүрийг хяналтад авч, нэмэлт төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг бүрэн хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, удирдлагын хяналтыг сайжруулж, албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлж ажиллах нь зүйтэй байна.

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын мөн оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтад заасан аргачлалын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодитой, биелэгдэхүйц, шалгуур үзүүлэлт нь тодорхой, хэмжигдэхүйц байхаар төлөвлөх, гүйцэтгэлийн тайлан нь иж бүрэн, алдаа мадаггүй, илтгэл үнэмшил төрүүлэхүйц үр дүнд суурилсан байхад анхаарах шаардлагатай байна.

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд нь 2024 онд давхардсан тоогоор 177 тайлан ирүүлэхээс 14 тайлан буюу 7.9 хувийг хугацаа хоцроосон, харин 6 тайлан буюу 3.38 хувийг тайлагнаагүй байгаа нь албан хаагчдын ажилдаа хандах хандлага, сахилга, хариуцлага сул, удирдлагын хяналт сул, энэ чиглэлээр бодит арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.

Байгууллагын 2024 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр “Эрчимжүүлэх шаардлагатай” үнэлгээ авсан Автотээврийн төв, Сум дундын ойн анги ОНӨААТҮГ, “Үр дүнгүй” буюу хангалтгүй үнэлгээ авсан Төрийн цахим үйлчилгээний хэлтэс нь үйл ажиллагаагаа сайжруулах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг эрчимжүүлэх шаардлагатай.

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагуудын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр үр дүнгүй үнэлэгдсэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн зөвлөмжийг удаа дараа хэрэгжүүлээгүй байгууллагуудын удирдлага, ажил хариуцсан албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

ТАЙЛАН БИЧСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Д.ЭНХЖАРГАЛ

Э.МӨНХТУЯА